

Туул тосгон

БНМАУ-ын Ардын Их хурлын тэргүүлэгчдийн 1983 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн зарлигаар Туул хороог Ажилчны район ОСГ-ын 14 хороо болгон байгуулсан.

Улсын Их хурлын 1995 он 16 дугаар тогтоолоор Хануул дүүрэгт нэгтгэн харьяалуулсан Туул дүүргийг Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 23 дугаар тогтоолоор тосгоны зохион байгуулалттай ажиллуулахаар шийдвэрлэсэн. Туул тосгоны оршин байгаа тухайн засаг захиргааны нэгжийн Засаг дарга тосгоны захирагч байх нь зүйтэй гэж тогтсон. Туул тосгоны ажлын алба нь НЗД-ын захирамжаар 12 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Тус хороо нь зүүн талаараа Хан-Уул дүүргийн 12 дугаар хороотой, баруун талаараа Төв аймгийн Алтанбулаг сумтай, хойд талаараа Сонгино-хайрхан дүүрэгтэй хил залган оршдог бөгөөд 5672 га нутаг дэвсгэртэй, Одоо тус хороо нь 1200 өрхийн 8404 хүн амтай, 270 өрхөд тэмээ 7 толгой, адуу 789 толгой, үхэр 7519 толгой, ямаа 8172 толгой нийт 19097 толгой малтай.

Сүүлийн жилүүдэд үхэр, гахай, шувууны фермерийн эрчимжсэн аж ахуй нэлээд хөгжиж одоогийн байдлаар 12 гаруй ферм, "Бөхөг" ХХК, "Түмэн шувууд" ХХК, "Угтуул" ХХК, "НСО" ХХК, "Халиу дайн хүү" ХХК, "Баячууд" ХХК зэрэг томоохон 20 шувууны аж ахуйн 18420 шувуу, БНСУ-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай "Коре-Алмаз" ХХК болон иргэд аж ахуйн нийлсэн 26 га-хайны аж ахуйд 5290 гахай өсгөн үржүүлж үйл ажиллагаа явуулж нийслэлийн иргэдийг хүнсний бүтээгдэхүүнээр хангаж байна.

Хорооны айл өрхүүд нь 11-18 км -т оршдог таруу байрлалыг харгалзан Засаг захиргааны анхан шатны нэгжийн хувьд 6 хэсэг байгуулан ажиллаж байна. нийслэл Улаанбаатар хотоос 37 км зайд хангайн бүсэд оршдог. Хорооны нутаг дэвсгэрт төсвийн байгууллага, томоохон компани зэрэг 30 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа явуулж байна.

Мөн 35 багш ажилчинтай 670 гаруй сурагчидтай 12 жилийн 26 дугаар дунд сургууль, 15 багш ажилчинтай 70 гаруй хүүхэдтэй 144 дүгээр цэцэрлэг, 21 эмч ажилчинтай Туул тосгоны хүн эмнэлэг, 32 ажилчин албан хаагчтай Онцгой байдлын гал унтраах 65 дугаар анги, Зэвсэгт хүчний 120 дугаар анги, Цагдаагийн хэсэг, Холбооны салбар, үсчин зурагчин, Мал эмнэлгийн Ту-да ХХК, нарийн боовны цех, цайны газар, халуун усны газар өдөр тутмын үйл ажиллагааг иргэдэд үзүүлж байна.

Мөн газар тариалан эрхэлдэг, 30 гаруй аж ахуйн нэгж 75-100 га эргэлтийн талбайд төс хүнсний ногоо, малын тэжээл тариалж нийслэлийн хүнсний хэрэгцээнд нийлүүлж, Туул тосгоны 13 дугаар хороонд Монгол Улсын хөдөлмөрийн баатар шувуучин Дэнсмаа, гавьяат эдийн засагч П.Санжид, дайнд оролцсон. ахмад дайчин З, Хорооны Засаг дарга Л.Батжаргал даргатай төрийн албан хаагчид төрийн үйлчилгээг ард иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, сурталчил-ах, цаг үеийн компани ажлуудыг цаг тухайд нь зохион байгуулан ажиллаж байна.